

**ИРГЭД ХАРИЛЦАН ЗОРЧИХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ
СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар /цаашид «Хэлэлцэн тохирогч Талууд гэх/,

хоёр орны хооронд найрсаг харилцааг өргөтгөн хөгжүүлэх, хүмүүс харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөхийг эрмэлзэн

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

Нэгдүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч Талын хүчин төгөлдөр дипломат буюу албан паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орох, гарах, дамжин өнгөрөхдөө виз авах шаардлагаас чөлөөлөгдөх бөгөөд оршин суух хугацаа нь орсон өдрөөс хойш 90 хоногоос хэтэрч болохгүй. Дээрх паспорт бүхий иргэдийн оршин суух хугацааг давагдашгүй хүчин зүйлийн улмаас сунгах бол паспорт эзэмшигч иргэнийг харъяалах Хэлэлцэн тохирогч Талын Дипломат төлөөлөгчийн газар эсхүл Консулын газрын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу сунгаж болно.

2. Энэ зүйлийн нэг дэх хэсэгт дурдсан паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт 90 хоногоос дээш хугацаагаар оршин суух бол урьдчилан виз авах үүрэгтэй.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан визийг харилцан хураамжгүй олгоно.

Хоёрдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт өөрийн орныг төлөөлөн сууж буй Дипломат төлөөлөгчийн болон Консулын газрын гишүүн, эсхүл олон улсын байгууллагад өөрийн орныг төлөөлөн сууж байгаа дипломат буюу албан паспорт бүхий Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт орох, гарахдаа виз авах шаардлагаас чөлөөлөгдөх бөгөөд томилолтынхоо хугацаанд тэндээ оршин суухаар зөвшөөрөгдөнө.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр хэсэгт дурдсан хүмүүсийн эхнэр буюу нөхөр болон хүүхдүүд дурдсан эрх ямбыг эдэлнэ. Тэгэхдээ тэдгээр нь дипломат болон албан паспорттай буюу хүүхдүүд нь өөрсдийнхөө аав буюу ээжийн паспортанд бичигдсэн байвал зохино.

Гуравдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч Талуудын хүчин төгөлдөр энгийн гадаад паспорт бүхий иргэдэд ажлын 1-2 өдрийн дотор харилцан хураамжгүйгээр виз олгоно.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газрын гишүүдийн урилгаар энгийн гадаад паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч

нөгөө Талын нутаг дэвсгэрт визгүй зорчиж болох ба энэ урилгыг тэдгээр Дипломат төлөөлөгчийн газар буюу Консулын газраас баталгаажуулсан байвал зохино. Энэхүү баталгаажуулсан урилга нь хүлээн авагч улсын хэлээр буюу англи хэлээр бичигдсэн байна.

Дөрөвдүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт орох, гарах буюу дамжин өнгөрөхдөө түүний олон улсын аялалд зориулсан боомтоор нэвтэрнэ.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын хүчин төгөлдөр паспорт бүхий иргэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа тухайн улсын холбогдох хууль, тогтоомжийг сахин мөрдөх үүрэгтэй.

3. Хэлэлцэн тохирогч нөгөө Талын иргэнийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэхээс татгалзах эсхүл оршин суух хугацааг богиносгох буюу цуцлах эрхийг Хэлэлцэн тохирогч аль ч Талын хувьд энэхүү Хэлэлцээр хязгаарлахгүй.

Тавдугаар зүйл

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт паспортаа үрэгдүүлсэн бол иргэн Хэлэлцэн тохирогч тухайн Талын цагдаагийн газар болон өөрийн улсын Дипломат төлөөлөгчийн газар буюу Консулын газарт мэдэгдэх бөгөөд тухайн Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар нь цагдаагийн байгууллагаас олгосон баримтыг үндэслэн өөрийн иргэндээ шинээр паспорт буюу зорчих баримт олгож энэ тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагуудад мэдэгдэнэ.

Зургадугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч хоёр Талын аль нь ч үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэндийг хамгаалах үүднээс энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоож болно. Хэлэлцэн тохирогч нэг Тал Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоох болон сэргээх тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд дипломат шугамаар мэдэгдэх бөгөөд Хэлэлцээрийг зогсоох буюу сэргээх хугацаа нь мэдэгдэлд заасан өдрөөс эхлэн үйлчилнэ.

Долдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд өөрсдийн хүчин төгөлдөр паспортын засвар буюу шинэ паспортын загваруудыг тус Хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос доод тал нь 30 хоногийн өмнө, эсхүл паспортыг хэрэглэж эхлэхээс нь өмнө урьдчилан дипломат шугамаар харилцан солилцоно.

Наймдугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээр нь гарын үсэг зурсан өдрөөс хойш 30 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Хэлэлцэн тохирогч Талууд дипломат шугамаар харилцан ноот солилцох замаар энэхүү Хэлэлцээрт нэмэлт эсхүл өөрчлөлт оруулж болно.

3. Энэхүү Хэлэлцээрийг тодорхой хугацаагүй байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч нэг Тал Хэлэлцээрийг цуцлахаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд дипломат шугамаар бичгээр мэдэгдсэнээс хойш 90 хоногийн дараа Хэлэлцээр хүчингүй болно.

4. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор 1985 оны 3 дугаар сарын 20-нд байгуулсан “Иргэдийг харилцан визээс чөлөөлөх тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээр” хүчингүй болно.

Энэхүү хэлэлцээрийг Ханой хотноо 2000 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр монгол, вьетнам, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүүтэй зүйл гарвал англи эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ
ВЬЕТНАМ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

Гарын үсэг